

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2025.04.28

Дугаар 01

Шарын гол сум

“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 14 цагаас 15 цагийн хооронд Дархан-Уул аймаг Шарын гол сум санжинт 3-р баг Шарын гол ХК-ийн өөрийн байр, 2 давхарын хурлын танхимд хуралдав.

Хурлын эхэнд Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож буй оролцогчдын ирцийг тооллогын комисс нэгтгэн гаргаж “хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай” ХЭХ-ын тооллогын комиссын 01 дүгээр тогтоолыг комиссын дарга /Э.Тодбаяр/ уншиж танилцуулав.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд нийт 12,423,825 ширхэг саналын эрхтэй хувьцааг төлөөлж 11,213,866 ширхэг энгийн хувьцаа эзэмшигч буюу 90,2 хувь нь хуралд ирснийг мэдээлж, Компанийн тухай хуулийн 69,1 дэх заалтын дагуу энэхүү ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсоныг уг тогтоолд дурдсан байна.

Хурлын дарга Б.Батбаатар Хуралд ирсэн хувьцаа эзэмшигч та бүхэнд баярласнаа илэрхийлье. Хурлын ирц хуульд заасан хэмжээнд хүрч байгаа тул хурлын үйл ажиллагааг нээж байна. Хурлын хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Өнөөдрийн хурлаас 3 тогтоол гаргах байгаа бөгөөд үүнд:

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон Санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах,
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай асуудлуудыг хэлэлцэн батална.

Гүйцэтгэх захирал Б.Мэндсайхан үйл ажиллагааны тайлан, Ерөнхий нягтлан бодогч Л.Эрдэнэжаргал санхүүгийн тайлангийн талаарх аудитын дүгнэлт, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Г.Өэлүн ТУЗ-ийн төсөв, засаглалын тайлангийн талаарх танилцуулгыг хийж, дараа нь асуулт хариултын үе шат явж, санал авахаар завсарлан, дараа нь санал тооллогын дүнг танилцуулж, хурлаас гарах тогтоолыг уншиж сонсгосноор дуусна.

1.ХЭЛЭЛЦСЭН НЬ: “Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай”

-Гүйцэтгэх захирал Б.Мэндсайхан: 2024 оны үйл ажиллагааны талаар дэлгэцэнд холбогдох мэдээллийг харуулан дэлгэрэнгүй танилцуулгыг хийв.

-Ерөнхий нягтлан бодогч Л.Эрдэнэжаргал: 2024 оны санхүүгийн тайлангийн талаар дэлгэцэнд холбогдох мэдээллийг харуулан дэлгэрэнгүй танилцуулга хийв.

-ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Г.Өэлүн: 2024 оны ТУЗ болон хувьцаа эзэмшигчдийн хурал, гаргасан шийдвэр, засаглалын талаар дэлгэрэнгүй тайлбарлан танилцуулав.

Г.Өэлүн: Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, тодруулах зүйл та бүхэнд байна уу гэхэд асуулт асуух хүн гарсангүй.

2.ХЭЛЭЛЦСЭН НЬ: ”Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах тухай”

Г.Өэлүн: Хурлаас гарах тогтоолын төсөлтэй та бүхэн танилцана уу гэв. Эндээс тодруулах асуулт байна уу гэхэд хуралд оролцогчдоос асуулт байхгүй гэв.

Хурлын дарга Б.Батбаатар: Хэлэлцэх асуудлын танилцуулга, асуулт хариулт явж дууссан тул одоо хувьцаа эзэмшигч та бүхэн хэлэлцэх асуудлаар саналаа өгнө, тооллогын комисс саналыг тоолох хугацаанд хурлын үйл ажиллагаа түр завсарлаж, тооллогын комисс тогтоолоо танилцуулснаар хурал үргэлжилнэ гэв.

Түр завсарлага 10 минут болов.

Хурлын тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсаар ирүүлсэн дүнг нэгтгэсэн тул хурал үргэлжлэв.

Тооллогын комиссын дарга Э.Тодбаяр тооллогын комиссын дүн, тогтоолыг танилцуулав.
Тус хурлаар шийдвэрлэсэн асуудал тус бүрийн зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо хувь, тооллогын комиссын тогтоол дугаар 02, 03, 04-г уншиж танилцуулав. Үүнд:

д/д	Хэлэлцсэн асуудал	Санал			
		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Хувь
1	Компанийн жилийн үйл ажиллагааны болон Санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах	11,213,866			100%
2	Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах	11,213,866			100%

1.	Компанийн гишүүдийг сонгох	ТУЗ-ийн	Санал өгөх эрх	Санал өгсөн эрх	Хувь
а)Ердийн гишүүд					
	Б.Батбаатар		100,924,794	11,411,889	11.3%
	Б.Мэндсайхан		100,924,794	11,411,839	11.3%
	Б.Дөлгөөнтамир		100,924,794	11,411,789	11.3%
	Б.Тулга		100,924,794	13,699,813	13.5%
	Б.Пүрэвбаатар		100,924,794	-	0.00%
	Ц.Тэмүүлэн		100,924,794	-	0.00%
	Б.Гэрэлтуяа		100,924,794	11,411,689	11.3%
	Н.Батнайрамдал		100,924,794	11,411,739	11.3%
б) Хараат бус гишүүд					
	Г.Хулан		100,924,794	10,055,400	9.9%
	Ж.Эрдэнэбат		100,924,794	10,055,290	9.9%
	Б.Итгэл		100,924,794	10,055,346	9.9%

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Хувыцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хэлэлцсэн асуудалтай холбогдуулан гарах тогтоолуудын төслийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Г.Өэлүн уншиж сонсгов. Үүнд:

1. “Компанийн жилийн үйл ажиллагааны болон Санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах”

2. “Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах”

3. “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай”

Эдгээр тогтоол болно. /тогтоолуудыг хавсаргав/

Хурлаас гарах тогтоолын төслүүдийн талаар асууж тодруулах зүйл байгаа эсэхийг асууж, Хурлын үйл ажиллагааг хаав.

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Г.Өэлүн

Г.ӨЭЛҮН

Танилцсан

ДАРГА



Б.БАТБААТАР